



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МАТЕРИАЛ

АГУУЛГА

- ❖ Мэндчилгээ
- ❖ “Шарын гол” ХК-ийн танилцуулга
- ❖ ТУЗ-ийн хурлын тогтоол
- ❖ ХЭХ-ын үйл ажиллагааны дараалал
- ❖ Хуралд хэлэлцэх асуудал
- ❖ ХЭХ-ын тооллогын комиссын тогтоол
- ❖ Хурлын дэг
- ❖ 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан
- ❖ 2020 оны аудитын тайлан /хураангуй/
- ❖ Компанийн засаглал, ТУЗ-ийн ажлын тайлан
- ❖ ТУЗ-ийн хурлын тогтоол
- ❖ ХЭХ-ын тогтоолын төсөл
- ❖ ХЭХ-ын тогтоолын төсөл
- ❖ ХЭХ-ын тогтоолын төсөл
- ❖ ТУЗ-ийн хурлын тогтоол
- ❖ Санал авах хуудас

МЭНДЧИЛГЭЭ



Монгол улс, бүс орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулан, оюун ухаан хүч хөдөлмөрөө зориулж, үндсэн үүргээ биелүүлсээр ирсэн тус компанийн нийт уурхайчид, хувьцаа эзэмшигчид, хамтран ажиллагч түнш байгууллага хамт олон та бүхэнд сайн сайхан бүхнийг хүсэн мэндчилье.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд хүрч ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

Тус компани нь Монгол улсын эдийн засгийн хямралыг даван туулж буй энэ цаг үед компанийн гол зорилго болсон дэлхийн стандартад нийцсэн уул уурхайн компани болох хөгжлийн ирээдүйд чиглэсэн бодлого тодорхойлж боловсронгуй болгон түүнийг хэрэгжүүлэхэд төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны үйл ажиллагаа чиглэж ирлээ.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйлдвэрийн шинэчлэл, цаашдын үйл ажиллагааны өрнөлттэй уялдуулан зайлшгүй шаардлагатай байгаа машин техник үндсэн хөрөнгө худалдаж авах, түрээсээр авч ажиллуулах тухай үйлдвэрийн үйл ажиллагаатай холбогдсон асуудал, компанийн удирдлага нэгжийн шинэчилсэн бүтцийн тухай, удирдлага зохион байгуулалтын асуудал зэрэг онцгой чухал асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж удирдамжаар хангаж байлаа.

Бидний цаашдын хөгжил дэвшилд хүрэх зорилго, зорилгоо биелүүлэхэд хувьцаа эзэмшигчид, харилцагч түнш байгууллагууд, уурхайчид нийт хамт олны хүч хөдөлмөр, хичээл зүтгэлээс шалтгаалан, хүндрэл бэрхшээлийг даван туулна гэдэгт итгэл төгс байгаагаа илэрхийлье.

Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

A handwritten signature in black ink, appearing to be the name 'G. Khulan'.

Г.ХУЛАН

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид ээ!

Монголын анхны механикжсан ил уурхай болох Шарын голын уурхай нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш улс орныхоо хөгжилд өөрийн тодорхой хувь нэмрийг тасралтгүй оруулсаар 56 дахь жилдээ амжилт бүтээлээр дүүрэн ажиллаж байна.

Уурхайчид бид бүхэн 2020 онд 8.6 сая шоо метр хөрс хуулж, 988.34 мян.тн нүүрс олборлон Хойд бүсийн эрчим хүч үйлдвэрлэгч Дархан, Эрдэнэт, Эрдэнэтийн УБҮ-ийн дулааны цахилгаан станцууд зэрэг томоохон хэрэглэгчдийн гэрээт нүүрсийг төлөвлөсөн хуваарийн дагуу амжилттай нийлүүлж, тэдгээрийн шаардлагад нийцсэн дунджаар 4334,4 ккал илчлэгтэй сайн чанарын нүүрсээр хангаж, гэрээний илчлэгийн зөрүүгээр 2.8 тэрбум төгрөгийн чанарын урамшууллын хуримтлалтай нүүрсний борлуулалт хийж үндсэн үүргээ амжилттай биелүүллээ.



Дэлхий дахинаа коронавирусын цар тахал дэгдэж Монгол орны хэмжээнд эрчим хүчний хэрэглээ буурснаас үүдэн манай гол эрчим хүч үйлдвэрлэгч станцуудын нүүрсний хэрэгцээ багассанаас шалтгаалан нүүрс олборлолт борлуулалтын хэмжээ бидний төлөвлөсөн үзүүлэлтэд хүрээгүй боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа нэг хором ч тасалдалгүй явуулж нийт хэрэглэгчид болон улс эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэртөртэй биелүүлэн төр засгийнхаа заавар зөвлөмжийг чанд баримтлан ажиллаа.

2020 оны ажлын ололт амжилт, бүтээлээ дүгнэн цэгнэхийн зэрэгцээ бид бүхэн 2021 ондоо алдсан, хийж амжаагүй зүйлсээ засаж сайжруулан гүйцээж, ажлын уялдаа холбоогоо улам нягтруулан ажлын хариуцлагаа чангатган хүрсэн амжилтаа улам бататган ажиллаж цаг үеийн хүндрэлийг даван гарах зорилттой ажиллаж байна.

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, уурхайчид, бизнесийн түнш, хамтран ажиллагсад та бүхний ажил үйлс өргөжин дэвжиж, аливаа эрсдэлээс ангид, ирээдүйд илүү итгэлтэй, амжилт бүтээл, аз жаргалаар дүүрэн байхын ерөөлийг өргөн дэвшүүлье!

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Х.УЯНГА

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ТАНИЛЦУУЛГА

“Шарын гол” Хувьцаат компани нь *“Газрын баялгийг гүн боловсруулж, хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, харилцагчийн хэрэгцээг эрхэмлэнэ”* гэсэн эрхэм зорилготойгоор Төлөөлөн удирдах зөвлөл, удирдлага, төлөвлөлт, үндсэн үйлдвэрлэл болон хангалт, үйлчилгээний бүтцийн нэгжүүдтэйгээр үйл ажиллагаа явуулж байна.

- ❖ **Нэр:** “Шарын гол” ХК
- ❖ **Үндсэн харьяалал:** Монгол улс
- ❖ **Хаяг:** Дархан-Уул аймаг, Шарын гол сум, 3-р баг Санжинт
- ❖ **Утас:** 7037-2235
- ❖ **Факс:** 7037-2235
- ❖ Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл Засгийн газрын 2003 оны 162 дугаар тогтоол, төрийн өмчийн хорооны 2003 оны 682 дугаар тогтоолоор 100 хувь, хувийн өмчит компани болсон.
- ❖ **Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар:** 1910010009
- ❖ **Регистрийн дугаар:** 2050374
- ❖ Тус компани нь Монгол улсын хойд бүсийн Дулааны цахилгаан станцууд болон Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр бусад хэрэглэгчид болох Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий байгууллагуудын үйл ажиллагааг нүүрсээр тасралтгүй ханган ажилладаг онцгой объектуудын нэг юм.
- ❖ **Компанийн эрх барих дээд байгууллага:** Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөл бөгөөд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг гүйцэтгэх захирал удирдана.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ



“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2, 3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 13⁰⁰ цагаас “Улаанбаатар” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.
 - а) Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах.
 - б) Компанийн ТУЗ-ийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
 - в) Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 - г) Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл
3. Хурал хуралдуулах тухай, хувьцаа эзэмшигчдэд зарлан мэдэгдэх өдрийг 2021 оны 3 дугаар сарын 22-ны өдөр байхаар тогтоосугай.
4. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2021 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр, саналын хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хурал хуралдах өдрөөр тус тус тогтоосугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын санал авах хуудасны загварыг хавсралт 1-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон, танилцах бичиг баримтын жагсаалтыг хавсралт 2-оор, хэвлэл мэдээллээр зарлах хурлын зарыг хавсралт 3-аар, тус тус баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг гүйцэтгэх захирал /Х.Уянга/, СТХ /Л.Эрдэнэжаргал/ нарт даалгасугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар, ТУЗ-ийн дарга Г.Хуланг томилсугай.
8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд: Комиссын дарга: – ТУЗ-ийн дарга Г.Хулан
Комиссын гишүүн: - Гүйцэтгэх захирал Х.Уянга
-Ө.Энхтайван - ТУЗ-ийн н/б дарга
9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.
Комиссын дарга: – Г.Өүлэн – Хангамжийн мэргэжилтэн
О.Хонгорзул – Архив, бичиг хэргийн ажилтан
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг, хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбогдуулан хийгдэх ажил, цаг хугацааны графикыг мөрдлөг болгон зохих хууль журмын дагуу хураллуулахыг комисс /Г.Хулан/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ХУЛАН



**“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ДАРААЛАЛ**

2021.04.27

Д/д	Үйл ажиллагаа	Хариуцагч
1.	Хуралд оролцох хувьцааг бүртгэн нэгтгэж хуралд мэдээлэл бэлтгэх	Тооллогын комисс Г.Өэлүн
2.	Хуралд ирсэн хувьцааны бүртгэлийн дүн бүхий тооллогын комиссын тогтоол танилцуулах	Тооллогын комисс Г.Өэлүн
3.	ХЭ-ийн хурал нээх	Хурлын дарга Г.Хулан
4.	ХЭ-ийн хуралд хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулах	Хурлын дарга Г.Хулан
5.	Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайланг танилцуулах	Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал Г.Мөнхбат
6.	Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлт	Гүйцэтгэх захирал Х.Уянга Ерөнхий нягтлан бодогч Л.Эрдэнэжаргал
7.	ТУЗ-ийн 2020 оны үйл ажиллагаа, компанийн засаглалын тайлан мэдээлэл	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван
8.	ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв батлах.	ТУЗ-ийн дарга Г.Хулан
9.	Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон ХЭ-ийн асуулт хариулт санал бодол	
10.	Завсарлага, санал тоолж нэгтгэх	Тооллогын комисс Г.Өэлүн
11.	Санал хураалтын дүнг хуралд танилцуулах /тооллогын комиссын тогтоол/	Тооллогын комисс Г.Өэлүн
12.	ХЭ-ийн хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулж батлуулах	ТУЗ-ийн н/б дарга Ө.Энхтайван
13.	Хурал хаах	Хурлын дарга Г.Хулан

ХУРЛЫН ТОВ: 2021 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 13:00 цагаас

ХУРЛЫН БАЙР: “Улаанбаатар” зочид буудлын Хурлын танхимд

ХУРАЛД ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1. Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
2. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл
3. Компанийн ТУЗ-ийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
5. Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

Төсөл

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 27

дугаар 01

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хурлыг
хүчин төгөлдөрт тооцох тухай

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 67.3.1; 67.3.8; 69.1 дэх заалтууд “Компанийн дүрэм”-ийн 7.4.1-ийн 9 дэх заалт, тооллогын комиссын гаргасан ээлжит хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг бүртгэн нэгтгэсэн дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2021 оны ээлжит хуралд нийт 10`170`242 ширхэг саналын эрхтэй энгийн хувьцааг төлөөлж ширхэг саналын эрхтэй энгийн хувьцаа бүгд хувь болсныг хуралд мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх заалт, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 4.7 дахь заалтын дагуу нийт саналын эрхтэй энгийн хувьцааны хувийн эзэмшигчид хуралд оролцож байгаа тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН
ДАРГА

Г.ӨЭЛҮН

“ШАРЫН ГОЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДЭГ

1. - Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах
Үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал - Г.Мөнхбат
/10 минут/
 - Компанийн 2020 оны санхүүгийн тайлан түүнд хийсэн аудитын тайлан танилцуулах
Ерөнхий нягтлан бодогч - Л.Эрдэнэжаргал
/10 минут/
 - Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл
ТУЗ-ийн дарга – ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Энхтайван
/10 минут/
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга – Ө.Энхтайван
/5 минут/
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга – Ө.Энхтайван
/5 минут/
4. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэртэй холбогдсон мэдээлэл
Гүйцэтгэх захирал – Х.Уянга
/5 минут/
5. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон асуулт, хариулт
/хүн тус бүр 3 минут/
6. Хэлэлцэж буй асуудалтай холбогдсон санал, санамж
/хүн тус бүр 4 минут/
7. Завсарлага, санал тоолж нэгтгэх
Тооллогын комисс
/15 минут/
8. Санал хураалтын дүнг танилцуулж, тооллогын комиссын тогтоол танилцуулах
Тооллогын комисс
/цаг тогтоохгүй/
9. Хурлаас гарах шийдвэр /тогтоол/-ийг хэлэлцэж батлах
ТУЗ-ийн нарийн бичгийн дарга – Ө.Энхтайван
/цаг тогтоохгүй/

Хурлыг 2 цагт багтаана.

/Хэрэв шаардлагатай бол хуралдах хугацааг хэлэлцэн сунгаж болно./

НЭГ: 2020 ОНЫ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ:

2020 онд 11,121.0 мян.м3 хөрс хуулж, 1,003.38 мян.тн нүүрс олборлохоор төлөвлөснөөс хөрс хуулалт 8,673.65 мян.м3 буюу 78%, нүүрс олборлолт 988.34 мян.тн буюу 99 %-н биелэлттэй байгаа ба өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулбал хөрс хуулалт 13%, нүүрс олборлолт 9%-иар бага байна. Бусад үзүүлэлтүүдийг хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт №01: 2019-2020 оны уулын ажлын гүйцэтгэл

д/д	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2019 он	2020 он		2020 оны төлөвлөгөөний биелэлт (%)
			Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	
1	Нүүрс олборлолт	м.тн	1,139.55	1,003.38	988.34	99%
2	Нүүрс борлуулалт	м.тн	1,128.53	1,093.83	1,004.32	92%
3	Хөрс хуулалт	м.м3	9,499.08	11,121.00	8,673.65	78%
4	Тээвэртэй	м.м3	9,499.08	10,308.00	7,993.67	78%
5	Тээвэргүй	м.м3	-	813.00	679.97	84%
6	Уулын цул	м.м3	10,375.65	11,892.83	9,433.91	79%
7	Шидэлт	м.м3	17.57	0	223.37	
8	Х.Х коэффициент	м.м3	8.34	11.08	8.78	79%

Хөрс хуулалтын коэффициент 2020 онд сүүлийн 5 жилийн хамгийн их буюу **8.78 м3/тн** байв.




УУЛЫН АШИГЛАЛТ:

Ашиглалтыг төвийн хойд блок болон өмнөд, хойд блокийн өргөтгөл блокуудад төлөвлөсөн.

Хүснэгт №02: Ашиглагдсан блокуудын нүүрсний төлөвлөгөө, гүйцэтгэл

№	Ашиглалтын блок	Төлөвлөгөө, мян.тн	Гүйцэтгэл, мян.тн
1	Төвийн хэсгийн хойд блок	698.1	809.07
2	Хойд блок өргөтгөл	20.0	7.0
3	Өмнөд блок	285.2	172.27




Зураг №01. Ашиглалтын блокуудын байрлал, ашиглалтын хүрээ

НӨӨЦ:

2013 онд батлагдаж ТЭЗҮ боловсруулагдсан нөөцийн хэмжээнээс 7,138.04 мян.тн нүүрс олборлосон. Жил бүрийн олборлолтын хэмжээг графикаар үзүүлье.

Хүснэгт №03. Ашиглалтын блокуудаас олборлосон хэмжээ



Хойд блокийг 2020 онд нээж, сайн чанартай **809.07 мян.тн нүүрс** олборлосон байна.

Жил бүрийн олборлолт өссөн дүнтэй байсан ч 2020 онд олборлолт коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас болж буурсан үзүүлэлттэй байна. Одоо үндсэн орд дээр 20,915.26 мян.тн нүүрсний үлдэгдэлтэй нэмэлт хайгуулаар Зүүн жигүүрийн блокт 4,2 сая.тн нүүрсний нөөц нэмэгдсэн бөгөөд нөөцийн нийт үлдэгдэл 25,115.07 мян.тн байна.

Нүүрс олборлолт /тн/									
SG	South floor	Remnant	Grave yard Ext	Grave yard	South Hight Wall	North Hight Wall	Buyant	North floor	Нийт
	Өмнөд ул	Өмнөд блок	Хойд блокийн өргөтгөл	Хойд блок	Төвийн өмнөд блок	Төвийн хойд блок	Зүүн жигүүр	Хойд ул	
мян.тн									
2013 он ТЭЗҮ нөөц	1,633,250.01	1,251,179.94	5,207,480.05	4,975,760.08	6,285,730.05	4,717,690.00		3,982,280.00	28,053,370.13
2013-2020 олборлолт	448,951.40	1,222,318.20	867,559.30	796,894.70	2,987,149.82	661,834.40		153,400.00	7,138,107.62
2020 онд нэмэгдсэн нөөц							4,199,810.00		4,199,810.00
Үлдэгдэл	1,184,298.61	28,861.74	4,339,920.75	4,178,865.38	3,298,580.23	4,055,855.60	4,199,810.00	3,828,880.00	25,115,072.31

2020 онд Зүүн жигүүрийн блокоос нэмэгдсэн нүүрсний нөөц.


Буянтын хэсэг дэх нүүрсний чийг /ТМ/ нь түлшний ажлын төлөвт 8.99-28.30 % дундаж нь 16.44 %, аналитик төлөвт 0.50-11.45 % хооронд хэлбэлзэж дунджаар 5.85 %, үнслэг /Ad/ нь хуурай төлөвт 9.24-44.97 % дунджаар 30.95 %, дэгдэмхий бодис /Vdaf/ нь шатах хэсгийн төлөвт 32.70-71.90 %-ийн хооронд хэлбэлзэж дунджаар 45.89 %, хүхэр /Sd/ нь хуурай төлөвт 0.38-6.26 % дунджаар 1.44 %, нүүрсний ажлын төлөв дэх илчлэг (Q_r) 2010-5190 ккал/кг, дундаж нь 3885 ккал/кг, нүүрсний шатах хэсгийн илчлэг (Q_{daf}) 3840-8405 ккал/кг-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд дунджаар 6886 ккал/кг байна.

Буянтын хэсэгт геологийн блокийн аргаар тооцоолсон бодитой В зэргээр 2,809,822.0 тн, боломжтой С зэргээр 1,389,988.0 тн, нийт бодитой В болон боломжтой С зэргээр 4,199,810.0 тн нүүрсний нөөцийг Ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэл (АМУНТБ)-д бүртгүүлсэн.

Хүснэгт №04. Зүүн жигүүрийн нөөцийн хэмжээ

Нүүрсний давхраа сын дугаар	Нөөцийн зэрэг, тн				Нийт нөөц, тн		Нийт нөөцөнд эзлэх хувь
	Бодитой (В)		Боломжтой С		В+С		
	Цэвэр нүүрс	Бохирдолт тооцсон нүүрс	Цэвэр нүүрс	Бохирдолт тооцсон нүүрс	Цэвэр нүүрс	Бохирдолт тооцсон нүүрс	
Д-0	-		434,854	454,359	434,854	454,359	10.4 %
Д-1	1,291,353	1,381,822	448,740	477,766	1,740,093	1,859,588	41.4 %
Д-2	848,525	894,312	300,631	319,030	1,149,156	1,213,341	27.4 %
Д-3	515,934	559,894	205,763	216,935	721,697	776,829	17.2 %
Д-4	154,010	165,061	-	-	154,010	165,061	3.7 %
Нийт	2,809,822	3,001,088	1,389,988	1,468,090	4,199,810	4,469,178	

ЗҮҮН ЖИГҮҮРИЙН ОРД:



Зураг №02. Зүүн жигүүрийн ордын байршил

НҮҮРСНИЙ ЧАНАР:

2020 онд олборлосон нүүрсний чанар /ж.дундаж/

Чийглэг %		Үнслэг %		Дэгдэмхий %		Бэхжигдсэн нүүрс		Дулаан гаргах чадвар ккал/кг	
W ^a	W ^p	A ^a	A ^p	V ^a	V ^g	FC ^{a/ad}	FC ^{p/ar}	Q ^b ^a	Q ⁿ ^p
2	13.9	28.5	25.3	30.5	44.3	34.7	30.8	4968.1	4054.3

Хойд бүсийн эрчим хүч үйлдвэрлэгч Дарханы, Эрдэнэт, Эрдэнэтийн УБҮ-ийн дулааны цахилгаан станцууд зэрэг томоохон хэрэглэгчдийн гэрээт нүүрсийг төлөвлөсөн хуваарийн дагуу амжилттай нийлүүлж, тэдгээрийн шаардлагад нийцсэн дунджаар **4334,4 ккал илчлэгтэй** сайн чанарын нүүрсээр хангаж ажиллаа.

2020 ОНЫ БОРЛУУЛАЛТЫН ТАЛААР:

Дэлхийн нийтээр Ковид цар тахлын хэмжээнд хүрч улс болон орон нутгийн үйлдвэр, аж ахуйн газрууд үйл ажиллагаагаа зогсоож, Монгол улсын хэмжээнд эрчим хүчний системийн хэрэглээ буурснаар нүүрсний хэрэглээ буурсан.

Борлуулалтын төлөвлөгөөний биелэлт 1,004,307 тонн 87%-тай, бол оны эхнээс 147,695 тонноор тасарсан бөгөөд цар тахлын улмаас Дархан ДЦС 45,105 тонн, Эрдэнэт ДЦС 38,514 тонн, Эрдэнэт үйлдвэр 73,874 тонноор борлуулалтын тасалдал үүссэн бол ТУЗ-н үнээр худалдан авалт хийдэг харилцагчдын борлуулалтын төлөвлөгөө давуулан биелсэн байна.

Дархан ДЦС	Эрдэнэт ДЦС	Эрдэнэт Үйлдвэр
3.20-ны 1/202 албан бичгээр 8,000 тн бууруулсан.	05.21-ны 5/465 албан бичгээр гэрээний 6-р сард авах нүүрсээ авахгүй болсноо мэдэгдсэн.	Гэрээний 3-р сарын хуваарьт нүүрснээс 7,330 тн дутуу авсан.
04.17-ны 1/365 албан бичгээр 10,000 тн бууруулсан.	06.23-ны 5/547 албан бичгээр гэрээний 7-р сард авах нүүрсээ авахгүй болсноо мэдэгдсэн.	Гэрээний 4-р сарын хуваарьт нүүрснээс 16,426 тн дутуу авсан.
06.16-ны 2/525 албан бичгээр 5,000 тн бууруулсан.	07.21-ны 5/593 албан бичгээр 08.10-ны өдөр хүртэл нүүрс авахгүй болсноо мэдэгдсэн.	Гэрээний 5-р сарын хуваарьт нүүрснээс 18,704 тн дутуу авсан.
12.03-ны 1/897 албан бичгээр 50,00 тн бууруулсан.		Гэрээний 6-р сарын хуваарьт нүүрснээс 29,387 тн дутуу авсан.
Бусад байдлаар 17,000 тн нүүрс авахаас татгалзсан.		

ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ:

Манай компани өнгөрсөн оны дүнгээр **8.6 сая шоо метр хөрс** хуулж, **988.34 мян.тн нүүрс** олборлосон.

Бидний хамтын хүчин чармайлтын үр дүнд Хойд бүсийн эрчим хүч үйлдвэрлэгч Дархан, Эрдэнэт, Эрдэнэтийн УБҮ-ийн дулааны цахилгаан станцууд болох томоохон хэрэглэгчдийн гэрээт нүүрсийг төлөвлөсөн хуваарийн дагуу амжилттай нийлүүлж, тэдгээрийн шаардлагад нийцсэн дунджаар **4334,4 ккал илчлэгтэй** сайн чанарын нүүрсээр хангаж, гэрээний илчлэгийн зөрүүгээр **2.8 тэрбум төгрөгийн** чанарын урамшууллын хуримтлалтай нүүрс борлуулалт хийсэн байна.

Дэлхий дахинаа коронавирусын цар тахал дэгдэж Монгол орны хэмжээнд эрчим хүчний хэрэглээ буурснаас үүдэн манай гол эрчим хүч үйлдвэрлэгч станцуудын нүүрсний хэрэгцээ багассанаас шалтгаалан нүүрс олборлолт борлуулалтын хэмжээ бидний төлөвлөсөн үзүүлэлтэд хүрээгүй боловч үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа нэг хором ч тасалдалгүй явуулж нийт хэрэглэгчид болон улс эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн төр засгийнхаа заавар зөвлөмжийг чанд баримтлан ажилласаар байна.

Хөрс хуулалтын хэмжээг өсгөн нэмэгдүүлж үйлдвэрлэлийн бүтээмж өсгөхөд онцгой анхаарч банкны зээлийн санхүүжилтээр Япон улсын HITACHI EX1900 6LD маркийн **6,8 тэрбум** төгрөгийн үнэ бүхий цахилгаан экскаватор, БНХАУ-н ХЕМС фирмийн SF3200IDC маркийн 110 тн-н **10,4 тэрбум** төгрөгийн үнэ бүхий өөрөө буулгагч хүнд даацын 4ш



автомашин шинээр худалдан авч, өөрсдөө угсарч ашиглалтад оруулж тус тус техникийн парк шинэчлэлт хийлээ. Мөн **80,8 сая** төгрөгийн үнэ бүхий сэрээт өргөгч /сэрээт ачигч/-ийг авч ашиглалтад оруулсан.

Үйлдвэрлэлийн зардлын 20 гаруй хувийг эзэлж байсан өрөмдлөг тэсэлгээний ажлын зардлыг багасгах зорилгоор тэсрэх материалын агуулахыг шинээр барьж байгуулан тэсэлгээний ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийг авч 2020 оны 11 дүгээр сараас тэсэлгээгээ өөрсдөө хийж эхлээд байгааг дуулгахад таатай байна.


Хэрэглэгчдэд нийлүүлж байгаа нүүрсний ангилан ялгалтанд нэлээдгүй хүндрэлтэй байсан технологи дамжлагын бутлуурын хацар плитаг сольсон, фракцын ангилалтыг хэрэглэгчийн шаардлагад нийцүүлэн нэг шугамаар хийж вагон ачдаг болсон, тоос дарах агааржуулах системийг шинэчлэн хийсэн зэрэг техник зохион байгуулалтын арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлснээр вагон ачилт хурдан шуурхай болж нүүрсний чанарын ангилалт, ажлын байрны нөхцөл сайжирсан.

Ажиллагсдын ая тухтай ажиллах нөхцөл бололцоог хангах ажлын хүрээнд ажлын байруудын засвар үйлчилгээг хийж, тавилга эд хэрэгслийг шинэчлэн, сурч боловсрох



нөхцөл боломжийг бүрдүүлэн номын сан, интернет танхим, бялдаржуулах фитнес танхим, нийтийн дасгал гимнастик, өглөөний алхалт зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол явуулж ирлээ.

Үйлдвэрийн талбай, карьер дахь технологийн горим дүрэм, дэг журам мөрдөлт, аюулгүй байдал хангахад нэлээд ахиц гарган ажилласнаар технологийн зөрчил буурч ажлын талбайн эмх цэгц, авто замын нөхцөл сайжирч, овоолго зохион байгуулалт, авто зам шинэчлэл, сайжруулалт, ус шүүрүүлэлт зэрэг инженерийн арга хэмжээнүүдийг тогтмол авч хэрэгжүүлж амжилттай ажиллаж байна.



Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сахих үйл ажиллагаандаа илүү анхаарч ажилласнаар уул-технологийн зөрчилгүй, ноцтой осол авааргүй ажиллаж, ажиллагсдынхаа хөдөлмөрлөх ажлын байрны нөхцөлийг сайжруулах тал дээр нэлээдгүй ахиц гарган ажиллаа.

“Эрчим хүчээ” хэмнэе аяныг өрнүүлэн, өдрийн цагаар шаардлагагүй гэрэл унтраах, цагийн ялгаварт тарифаар тооцох, 22 цагаас хойш вагон ачих зэрэг бүтээлч ажлуудыг санаачлан хийж гүйцэтгэснээр **209.1 сая төгрөгийн цахилгааны зардал** хэмнээд байгаа нь маш үр дүнтэй ажил болсон байна.

Засварын ажлын үр дүнг дээшлүүлэх, түргэн шуурхай байдлыг хангах зорилгоор шаардлагатай багаж хэрэгсэл, оношлогооны төхөөрөмжөөр хангаснаар засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэж байна.

CAT-16G автогрейдерийг засварлаж олон жилийн дараа ажилд оруулсан, ЭКГ-4У экскаваторын загварыг өөрчлөн ЭКГ-8и экскаватор болгон засварласан зэрэг олон ажлуудыг хийж гүйцэтгэснээр компанид **481,4 сая төгрөгийн хэмнэлт** гаргасан байна.



Цар тахалтай холбогдон нийтийг хамарсан нийгмийн чиглэлд бидний төлөвлөсөн ажлууд бүрэн хийгдээгүй боловч сум орон нутгийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд хүн хүч техник хэрэгслээр байнга тусалж, хөл хорионы хугацаанд гэр хорооллын ард иргэдэд нүүрс хүргэх, амьжиргааны төвшин доогуур гэр бүлд туслах зэрэг хүмүүнлэгийн үйл ажиллагааг явуулж ирлээ.

2020 оны Хамтын гэрээний заалтын дагуу сургалт хөгжлийн зардалд **34.9 сая.төг**, буцалтгүй тусламжаар **15.3 сая.төг**, тэтгэмжээр **47.4 сая.төг**, нүүрсний хөнгөлөлтөөр **28.4 сая.төг**, шагнал урамшууллаар **20.6 сая төгрөг** тус тус ажилчдадаа олгоод байна.

Өнөөдрийн байдлаар компанид 419 ажилтан ажиллаж байна.

55 ЖИЛИЙН ОЙН ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

Өнгөрөгч 2020 онд “Шарын гол” ХК-ийн 55 жилийн түүхэн ойн тохиосон бөгөөд ойн хүрээнд ажлын амжилтаараа хамт олноо манлайлан ажилласан нийт 87 уурхайчин шагнагдсанаас Монгол улсын “Тэргүүний уурхайчин” цол тэмдэг болон салбарын тэргүүний ажилтны цол тэмдгээр 26 ажилтан шагнагдсан байна.



Дэлхий дахинд дэгдсэн коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахал гарч Монгол Улсын Засгийн газраас түүхэн тэмдэглэлт өдөр, ойг тэмдэглэх ажлыг хориглосонтой холбогдуулан хязгаарлагдмал нөхцөлд хамт олны бүтээлч үйл ажиллагааг хөгжүүлэх, урамшуулах хэлбэрийн зохион байгуулах, түүхэн хугацаанд өндөр амжилт гарган ажиллаж байсан ахмадуудыг алдаршуулах ажлыг дараах 5 үе шаттайгаар зохион байгуулсан. Үүнд:



Нэгдүгээр үе шат: Шарын голын уурхай байгуулагдсан түүхэн өдөр олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ явуулах, уурхайн ажилчидтай халдваргүйжүүлэлтийн нөхцөлийг хангасан орчинд уурхайн зоогийн газарт нээлтийн ажиллагаа зохион байгуулах;

Хоёрдугаар үе шат: Бүтээн байгуулалт, завсар үйлчилгээний ажлыг өрнүүлэн уурхайн зам талбайг засварлах, нэвтрэх орчныг сайжруулах, замын уулзварын самбарыг шинэчлэх, КАТ-ын хөшөөний дэргэдэх “Шарын гол” гэсэн тэмдгийг зөөж байрлуулах, уурхайн төв байрны хананд “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонг хийж байрлуулах, уурхайн төв байр, нүүрс ангилан ачих хэсгийн гадна засвар зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэх;



Гуравдугаар шат: 2019-2020 оны жилийн ажлын үр дүнг үнэлэх, дүгнэх, 2020-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах, гавъяат үйлстэй ахмадуудыг тодруулах ажлыг хэрэгжүүлэх;

Дөрөвдүгээр үе шат: Жилийн ажлын дүн гаргаж, ажлын үр дүнгээр тэргүүлсэн албан хаагчдыг шагнаж урамшуулах, нийт албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн шийдвэр гаргах, баярын цуглааны арга хэмжээг цар тахлын хорио цээрийн дэглэмийг сахиулан тодорхой хэмжээ тогтоон зохион байгуулах;

Тавдугаар үе шат: Хорио цээрийн дэглэм буурах, цуцлагдсан тохиолдолд ахмадуудад хүндэтгэл үзүүлэх ажлыг тусгай төлөвлөгөөний дагуу зохион байгуулах зэрэг ажлуудыг тус тус хийж гүйцэтгэлээ.

КОРОНАВИРУС ЦАР ТАХЛЫН ҮЕД ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АЖЛУУД:

Үйл ажиллагааны чиглэлээр хийгдэж буй ажлууд:

Шарын голын нүүрсний уурхай нь Шарын гол суманд Ковид-19 илэрсэн нөхцөлд ажиллах төлөвлөгөөтэй бэлтгэл ажлаа хангасан бөгөөд Гамшгийн эрсдэлийг бууруулах, Гамшгаас хамгаалах төлөвлөгөө, Ковид-19 цар тахлын үед ажиллах төлөвлөгөө, Цар тахлын халдварын үед мөрдөх, үйл ажиллагаа зохион байгуулалтын түр журам баримтлан Дархан, Эрдэнэт, Эрдэнэт УБҮ-ийн станцуудыг нүүрсний нөөцөөр хангасан бөгөөд мөн бусад гэрээт хэрэглэгчдийг нүүрсээр жигд тасралтгүй хангах, үйлдвэрлэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байхаар хүн хүч техникийн зохион байгуулалт хийж ажиллаж байна.

Мөн инженер техникийн ажилтнуудыг онлайнаар ажиллуулж, бусад ажилтнуудад Монгол улсын “Хөдөлмөрийн тухай” хуулийн дагуу сул зогсолтод хамруулсан.

Цар тахлын үед авсан арга хэмжээ:

- Хэсэг нэгжийн удирдлагууд ажилтнуудыг ажилд гарахын өмнө биеийн халууныг хэмжиж дэвтэрт тэмдэглэл хөтөлж байна.

- Үйлдвэрийн эмнэлгийн бага эмч нар цайны цагуудаар давхардсан тоогоор 3131 ажилтны гарыг угаалгаж ариутгуулсан, 3209 ажилтны биеийн халууныг хэмжсэн, 2484 ажилтны амны хаалтын хэрэглэнд хяналт тавьж, 3520 ажилтныг хүн хоорондын зай бариулан хооллосон.

- Уурхайн 537 ажлын байр, өрөө тасалгаанд 33,332 м² талбай, 78 машин техникт ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

- Ажлын байрууд, нарядын өрөө, бие засах газарт гар ариутгагчийг байрлуулж ажилтнуудын гарыг тогтмол ариутгуулж байна.

- Нийт ажилтнуудаас түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авах ажлыг зохион байгуулж 456 ажилтан хамрагдсан ба хариу бүгд сөрөг гарсан.

- Ажилтнуудын дархлааг дэмжих зорилгоор 410 литр халуун аарц, 290 литр



чацарганы ундаа, Витамин С, РЕВИТ үрлийг тус тус олгосон.

- Компанийн нөөцөнд нэг удаагийн маск-30,000 ш, санитол-120л, спирт-50л, нэг удаагийн комбинзон-650ш, жаволин-21 хайрцаг, нүүрсний хаалт-20ш, түргэн оношлуур-265ш тус тус байна.

СУРГАЛТ ХӨГЖЛИЙН ТАЛААРХ АЖЛУУД:

Өнгөрөгч онд бид компанийхаа дэргэд мэргэжлийн сургалтын төв байгуулсан томоохон амжилттай ажилласан. “Шарын гол” ХК-ийн дэргэдэх “Шарын гол” сургалтын төв нь хүнд машин механизмын оператор, уул уурхайн машин тоног төхөөрөмжийн механик, наладчик, цахилгаанчин, цахилгаан тоног төхөөрөмжийн засварчин, гагнуурчин мэргэжлүүдээр богино хугацааны чадамжид суурилсан сургалт явуулж, уурхайн талбарт дадлагажуулан, мэргэжилтэй ажилчдаа дотооддоо бэлтгэхийн зэрэгцээ уул уурхайн салбарын хүний нөөцийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулсаар байна.



Цар тахлын улмаас сургалтын үйл ажиллагаа бидний төлөвлөсөн хэмжээнд хүрч явагдаагүй ч бүх хөтөлбөрүүдээ амжилттай хэрэгжүүлэн, ажилчдынхаа мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд анхаарч ажиллаж байгаа бөгөөд Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээ, мэдээлэл арга зүйн төвтэй хамтран чадамжийн үнэлгээг амжилттай зохион байгуулсан. Тайлант хугацаанд дараах сургалт, хөгжлийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Хоёр удаагийн элсэлтээр 62 оператор, 7 наладчик, 5 механик, 3 гагнуурчин, 1 цахилгаанчин, 1 ороомогчин нийт 79 мэргэжилтэй ажилтанг сургаж бэлтгэн, ур чадварын үнэлгээнд хамруулж, ХНХЯ-ны зөвшөөрөл бүхий албан ёсны чадамжийн гэрчилгээг олгуулсан.
- Нийт 205 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 4518 ажилтанг хамруулсан.
- ИТА аттестатчлалыг амжилттай явуулсан.
- Нийт ажилтны аттестатчлалыг дотооддоо зохион байгуулж, 372 ажилтан буюу нийт ажиллагсдын 82.6%-ийг хамруулсан.
- Уурхайн виртуал орчин бүхий дамп трак-гидро экскаваторын хосолсон сургалтын симуляторыг захиалгаар хийлгэн сургалтад ашиглаж байна.
- Сургалтын төвдөө номын сантай болсон.
- Удирдлагын багийн сургалт болон инженер техникийн ажилтнуудын чуулга-уулзалтыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж байна.
- Зөөлөн ур чадварын сургалтад түлхүү зохион байгуулах зорилттой ажиллаж байна.
- Сургалтын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлэн ажиллаж байна.




БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТ:

2020 оны хугацаанд бохирын болон цэврийн нуур өмнөх онуудад ашигласан блокуудад байршуулах, Шарын голын нүүрсний уурхайгаас шүүрлээс ус татах хоолойг мөн зарим хэсгийг нь зөөвөрлөх, шинээр холбох гэх мэт усны хоолой татаж, уурхайгаас шүүрч байгаа усыг насосоор татаж, цэврийн нуураа дүүргэх, шимт болон өнгөн хөрс хуулах, тусад нь овоолох гэх мэт ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Нөхөн сэргээх ажлын талаар:

2020 онд техникийн нөхөн сэргээлтийг олборлолт явуулсан 6.1 га, нүүрсний уурхайн ухаш болох 4.9 га талбайд нөхөн дүүргэлтийн ажил хийгдсэн. Мөн түүний 2.6 га талбайд нь биологийн нөхөн сэргээлт хийсэн.



Зураг 1. Буянтын хөндийн адаг хэсгийн алтны шороон ордын уулын ажлын дэвсгэр

Дүйцүүлэн хамгаалах чиглэлээр хийгдсэн ажлын талаар:

“Шарын гол” ХК-ийн уурхайн захиргаа төв пост орчимд шимт хөрсөөр хучилт хийж, олон наст үр /согоовор/ тарьсан. Нийт 1.5 га талбай, 1200м³ шимт хөрсөөр хучилт хийсэн.



Зураг 2. Шимт хөрс хучсан талбайг хашаажуулан олон наст үр тарьсан. 2020 оны 8 сар



Зураг 3. Уурхайн цайны газрын хажуу талыг шимт хөрсөөр хучиж зүлэг тарьсан.
2020 оны 8 сар



Зураг 4. Уурхайн захиргаа орчимд эвдэрсэн газрыг тэгшилж мод тарьж, шимт хөрсөөр хучиж зүлэг тарьсан.

2020 оны төлөвлөгөөнд 01С, 1С, 2С, 3В блокуудыг бүрэн мөн 4В, 5В, 6В-н үлдэгдэл цэвэр усны шугамын баруун талыг ашиглаж дуусгахаар тусгасан. Гэвч хөрс хуулалтын ажлын хэмжээнээс хамаарч 01С, 1С, блок 4В, 5В, 6В-н үлдэгдэл бүрэн ашиглаж дуусгасан ба 01С, 1С, 4В, 5В, 6В блокт хамаарах талбайд олборлолтыг явуулж 661 мян.м³ хөрсийг дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлтэд ашиглалаа.

2020 онд техникийн нөхөн сэргээлтийг олборлолт явуулсан 6.1 га, нүүрсний уурхайн ухааш болох 4.9 га талбайд нөхөн дүүргэлтийн ажил хийгдсэн. Мөн түүний 2.6 га талбайд нь биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.

ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД ХИЙГДСЭН АЖЛУУД:

ХАНДИВ ТУСЛАМЖ	27,642,524.69
Ахмад болон хүүхдийн автобус /цалин /	5,098,818.18
Ковид-той холбоотой тусламжууд /түлш, нүүрс/	2,318,356.51
Ковид-той холбоотой тусламжууд /нүүрс 254.9тн/	18,225,350.00
ДУАНЭ мэдрэлийн тасагт	1,000,000.00
Ахмадын хороонд	1,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТУУД	69,494,261.89
2020 оны 9-р сарын 14-ны өдрийн 16 дугаар ТУЗ-ын тогтоолоор Старекс 01-24 ДАХ түргэний машиныг сумын эмнэлэгт хандивлав.	5,179,789.16
“Өгөөмөр баян булаг” ХХК СОНХАГЭрээний хүрээнд хийгдсэн Инженерийн шугамын 2-р ээлжийн ажилд	64,314,472.73
Нийт	97,136,786.58



**ХОЁР: 2020 ОНЫ ХАРААТ БУС АУДИТОРЫН
ТАЙЛАН /ХУРААНГУЙ/**



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ШАРЫН ГОЛ” ХХК

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар
болгон нэгтгэсэн санхүүгийн тайлан





**БЭЙКЕР ТИЛЛИ
ДАЛАЙВАН АУДИТ**

Аудит, баталгаажуулалт, хөрөнгөний болон
бизнесийн үйлдлэл, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Бажигал дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005402
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@bakerillyaudit.mn
Вэб хуудас: www.bakerillyaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**“ШАРЫН ГОЛ” ГРУПП -ИЙН
Хувьцаа эзэмшигчид танаа**

Дүгнэлт

Бид 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн “Шарын Гол ХК (цаашид “Компани” гэх) болон түүний охин компаниудын (цаашид хамтад нь “Групп” гэх) -ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Группийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх нэгтгэсэн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон нэгтгэсэн мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх) -ын дагуу материаллаг алдаагүй үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн үнэлэмжээр тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал асуудал байдаг. Нэгтгэсэн Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн бөгөөд эдгээр асуудлууд тус бүрт ямар нэг дүгнэлт гаргаагүй болно.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)	Аудитаар авч хэрэгжүүлсэн арга хандлага
<u>Уурхайн хөрөнгийн дансны үнэ ба олборлолтын өртөг:</u>	
<p>Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 20,299,266 мянган төгрөгийн дансны үнэ бүхий уурхайн хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт болон хэмжилт нь тодорхой шийдлийг удирдлагаас шаарддаг. Групп нь бүтээгдэхүүний нэгжид ногдуулах аргыг ашигладаг бөгөөд уурхайн нийт нөөцийг тодорхойлох болон уурхайн хөрөнгийг үйлдвэрлэлийн нэгжид хуваарилахтай холбоотой шийдлүүд гаргадаг.</p>	<p>Бид 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх нүүрсний агууламж, түвшин болон нягтралын талаарх мэдээллийг ТЭЗҮ дэх мэдээлэлтэй тулгаж шалгасан. ТЭЗҮ боловсруулахад удирдлагын ашигласан өгөгдлүүд, мэргэжлийн ур чадвар болон бодитой байдлыг үнэлсэн. Тайлант жилийн турш капиталжуулсан зарцуулалтуудын дэлгэрэнгүй тест гүйцэтгэж, тухайн зарцуулалтуудын үнэн зөв, иж бүрэн байдлыг үнэлсэн. Мөн бид бараа материалын цэвэр боломжит үнэ цэнийн тесттэй холбоотойгоор ирээдүйн нүүрсний үнэ болон одоогийн нүүрсний үнийг харьцуулж, зах зээлийн хандлагыг харгалзан үзсэн. Мөн уурхайн хөрөнгөтэй холбоотой үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг илэрхийлсэн аливаа зүйл байхгүй талаарх удирдлагын үнэлгээг чухалчлан авч үзсэн.</p>
<u>Нөхөн сэргээлтийн сангийн нөөц:</u>	
<p>2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Группийн нөхөн сэргээлтийн сангийн үлдэгдэл нь 14,972,007 мян.төгрөг байсан. Группийн нөхөн сэргээлтийн нөөцийг тодорхойлсон шийдлийг удирдлагаас шаарддаг. Нөөцийг тодорхойлоход мөнгөний урсгал, зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай ажлыг гүйцэтгэхэд удирдлагын үнэлэмж хэрэгтэй байдаг.</p>	<p>Бид ирээдүйн зардлын төлөвлөгөө, өртгийн загварыг бэлтгэхэд удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, бодитой байдлыг үнэлсэн. Бид уурхайн зардлын төлөвлөгөө, зардлын загварчлалыг үнэлсэн бөгөөд уг загварчлал дахь гол тооцоолол болон тосөөллийг үнэлсэн. Түүнчлэн бид нөхөн сэргээлтийн хүлээгдэж буй хугацааг уурхайн ашиглалтын хугацаанд тооцоолж, хүлээгдэж байгаа мөнгөн урсгалд ашигласан дискаунтын түвшнийг үнэлсэн.</p>
<u>Ажилчдын тэтгэврийн сангийн нөөц:</u>	
<p>Группийн нэгтгэсэн санхүүгийн тайланд 1,938,121 мянган төгрөгийн тэтгэмжийн сангийн нөөц үлдэгдэлтэй байсан. Группийн Ажилчдын тэтгэврийн нөөцийг тодорхойлоход хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй мөнгөн урсгалын зохистой дискаунтын түвшин зэрэг шаардлагатай нарийн төвөгтэй ажлыг гүйцэтгэхэд удирдлагын шийдэл шаардагдах учраас бид энэ асуудлыг аудитын гол асуудалд оруулсан.</p>	<p>Бид аудитын явцад хөндлөнгийн актуарчийг аудиторын шинжээчээр ажиллуулж, тэтгэмжийн сангийн тооцооллтой холбоотойгоор удирдлагын ашигласан мэргэжлийн ур чадвар, тооцооллын бодитой байдлыг үнэлсэн. Үүнд хүлээгдэж буй мөнгөн урсгал, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хуваарилалт, зохистой дискаунтын түвшин зэргийг үнэлсэн. Энэхүү аудиторын шинжээчийн ажилд суурилан бид удирдлагын тооцооллыг үндэслэлтэй гэж үнэлсэн.</p>

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт Гүйцэтгэх Удирдлагын мэдэгдэл багтана. Бусад мэдээллийг энэхүү аудиторын тайланг гаргасан өдрөөр бидэнд бэлтгэн хүргүүдэг.

Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа дүгнэлт өгөхгүй юм.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг бэлэн болсон үед унших үүрэгтэй бөгөөд уг бусад мэдээлэл нь нэгтгэсэн санхүүгийн тайлан эсвэл аудитын явцад цуцлуулсан мэдээлэлээс материаллаг хэмжээний хувьд алдаатай эсэхийг авч үзнэ.

Бусад мэдээлэлтэй танилцаад, материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай байвал бид удирдлага болон засаглах эрх бүхий этгээдэд мэдэгдэж аудитын бусад горим хэрэгжүүлж дараах зүйлийг тодрохойлно. Үүнд:

- Бусад мэдээлэл нь материаллаг хэмжээний зөрүүтэй эсвэл алдаатай эсэхд,
- Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд нь материаллаг хэмжээний алдаатай эсэхд эсвэл,
- Бидний олж авсан Группийн болон түүний орчины талаарх ойлголтоо шинэчлэх эсэхд.

Хэрэв бид хийсэн аудитлаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагналтай байна гэж үзсэн бол залруулагдаагүй материаллаг хэмжээний алдааг бидний гаргасан тайлан хэрэглэгчдэд мэдээлэхийн тулд зохистой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг засаглах эрх бүхий этгээдээс хүсэх болно.

Хэрэв Группийн нэгтгэсэн санхүүгийн тайлангууд болон группийн болон түүний орчины талаарх бидний олж авсан ойлголт материаллаг хэмжээний алдаатай байна гэж үзсэн бол бид АОУС-ын дагуу холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв, шударгаар толилуулах үүрэг хүлээхээс гадна санаатай залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг хэмжээний алдаагүй бэлтгэж шударгаар илэрхийлэхийн тулд удирдлагаас шаардлагатай дотоод хяналтуудыг хэрэгжүүлнэ.

Нэгтгэсэн Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага группийн үйл ажиллагааг зогсоох, татан буулгах, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага Группийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэж тодруулан, Нягтлан Бодох Бүтгэлийн Нийтээр Хүлээн Зөвшөөрөх Зарчмын тасралтгүй байх суурийг ханган нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэх үүрэгтэй.

Группийн удирдлага болон засаглах эрх бүхий этгээд нь Группийн Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ алдаа эсвэл залилангаас үүдэх материаллаг хэмжээний алдаагүй илэрхийлэгдсэн эсэх талаар ул үндэстэй нотолгоог олж авах болон өөрийн дүгнэлтийг агуулсан аудиторын тайланг бэлтгэн гаргах юм. Ул үндэстэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа материаллаг хэмжээний алдаа бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайланд тулгуурлан шийдвэр гаргах хэрэглэгчидийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлал бий болсон бол материаллаг гэж үзнэ.

АОУС-ын дагуу бид аудит гүйцэтгэх явцдаа мэргэжлийн үнэлэмжээ ашиглан, мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилласан. Мөн бид:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлон үнэлж, тэдгээр эрсдэлүүдэд тохирох хариу аудитын горимуудыг хэрэгжүүлж, мөн аудитын дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийлэлийг илрүүлэхгүй байх эрсдэлээ өндөр байна. Залилан нь хуйвалдах, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг хэрэгжүүлэхгүй байхаас үүссэн байж болно.
- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт авч судалдагч энэ нь дотоод хяналтын үр дүнтэй байдал дүгнэлт өгөх зориллогүй юм.
- Группийн хэргэжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын нягтлан бодох бүртгэлд хийж буй таамаглал болон холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлдэг.
- Хэрэв группийн тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид нэгтгэсэн санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөж болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайлангийн өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилна. Гэвч ирээдүйд болох үйл явдал эсвэл нөхцөл байдал Группийн үйл ажиллагаагаа хэвийн явуулахад саад учруулж болох юм.
- Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга, бид үнэлэж, нэгтгэсэн санхүүгийн тайланг үнэн зөв толилуулсан эсэхийг ажил гүйлгээ, үйл явдлуудыг толилуулсан эсэхийг үнэлдэг.
- Нэгтгэсэн Санхүүгийн тайланг аудитын дүгнэлт өгөхдөө Группийн аж ахуйн нэгжийн болон бизнесийн үйл ажиллагаа, нэгтгэсэн санхүүгийн мэдээлэлийн талаар хангалттай зохистой нотолгоонд суурилсан. Бид группийн аудитын гүйцэтгэлд, түүнийг удирдан зохион байгуулахтай холбоотой үүргийг хүлээдэг. Бид аудитын дүгнэлтийн талаар үүрэг хүлээдэг.

Бид удирдлага, засаглах эрх бүхий этгээдтэй аудитын ажлын цар хүрээ, хугацаа, болон аудитын явцад илэрсэн анхааралд өртөхүйц асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцдаг.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
(үргэлжлэл)

Нэгтгэсэн Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад асуудал

Энэхүү тайланг өөр ямар нэг зорилгоор биш, Монгол Улсын компаний тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчидийн зориулан аудитыг гүйцэтгэсэн болно. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд аливаа бусад этгээдийн өмнө хариуцлага хүлээхгүй болно.



БЭЙКЕР ТИЛГИН ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2021 ОНЫ 4 ДҮГЭЭР
САРЫН 9-НИЙ ӨДӨР

**ШАРЫН ГОЛ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

АГУУЛГА

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэгтгээн Санхүүгийн Байдлын тайлан.....	1
Нэгтгээн Дэлгэрэнгүй Орлогын тайлан.....	2
Нэгтгээн Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
Нэгтгээн Мөнгөн гүйлгээний тайлан.....	4-5
Нэгтгээн санхүүгийн тайлангийн тодруулгууд.....	6

**ШАРЫН ГОЛ ХК БОЛОН ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГУУД
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН**

Ерөнхий мэдээлэл

ТУЗ-ийн дарга	Г.Хулан (ТУЗ-ийн дарга)-Хараат бус
ТУЗ-ийн гишүүд	Б.Батбаатар (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Ж.Эрдэмбилэг (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Ө.Хишигсүх (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Б.Итгэлт (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Т.Говь-Дэлгэр (ТУЗ-ийн гишүүн)-Хараат Б.Тулга (ТУЗ-ийн гишүүн)-Хараат М.Батсүрэн (ТУЗ-ийн гишүүн)-Хараат бус О.Цэндсүрэн (ТУЗ-ийн гишүүн)-Хараат бус
Нарийн бичгийн дарга	Ө.Энхтайван (ТУЗ-ийн нарийн бичиг)
Гүйцэтгэх удирдлага	Х. Уянга
Харьцдаг гол банкууд	Худалдаа Хөгжлийн банк Голомт банк Хаан банк Төрийн банк Богд банк
Албан хаяг	Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж – 5, Далайван Аудит ХХК-ийн байр
Аудиторууд	БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

**ШАРЫН ГОЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Толруулга	2020	2019
Хөрөнгө			
<i>Эргэлтийн хөрөнгө</i>			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	5	3,400,271	302,234
Дансны болон бусад авлага	6	4,152,827	4,136,045
Урьчилж төлсөн зардал ба бусад эргэлтийн Хөрөнгө	7	2,934,333	4,164,798
Бараа материал	8	4,584,274	2,977,562
		15,071,705	11,580,639
<i>Эргэлтийн бус хөрөнгө</i>			
Үндсэн хөрөнгө	9	24,166,503	35,733,833
Биет бус хөрөнгө	10	17,504	478,677
Ашиглах эрхтэй түрээсийн хөрөнгө	11	22,528,396	10,010,307
Уурхайн хөрөнгө	12	20,299,266	17,926,480
Хөрөнгө оруулалт	13	458,802	33,812
Хойшлогдсон татварын хөрөнгө	21	313,787	-
Бусад эргэлтийн бус хөрөнгүүд	14	881,002	983,779
		68,665,260	65,166,888
Нийт хөрөнгө		83,736,965	76,747,527
Ор төлбөр ба эзэмшигчдийн өмч			
<i>Богино хугацаат ор төлбөр</i>			
Дансны болон бусад өглөг	15	13,097,143	13,379,982
Богино хугацаат зээл	16	16,807,602	9,641,356
Богино хугацаат түрээсийн өглөг	11	3,849,400	2,792,679
Гэрээний ор төлбөр	17	61,389	316,334
Хүүгийн өглөг	11	1,154,534	1,231,522
Хурааж	18	60,941	124,881
Богино хугацаат нооц	19	37,960	30,262
Татварын өглөг	20	977,022	913,922
		36,045,991	28,430,938
<i>Урт хугацаат ор төлбөр</i>			
Урт хугацаат зээл	16	-	9,917,844
Урт хугацаат түрээсийн өглөг	11	10,187,577	1,021,796
Урт хугацаат нооц	19	17,694,810	15,331,917
Хойшлогдсон татварын ор	21	9,000	29,187
		27,891,387	26,300,744
Нийт ор төлбөр		63,937,378	54,731,682
Эзэмшигчдийн өмч			
Хувьцаат капитал	22	1,017,024	1,017,024
Нэмж төлөгдсөн капитал	22	23,145,158	23,145,158
Дахин үнэлгээний нэмэгдэл	22	16,959,698	17,338,234
Хуримтлагдсан ашиг		(21,322,293)	(19,484,571)
		19,799,587	22,015,845
Нийт ор төлбөр ба Эзэмшигчдийн өмч		83,736,965	76,747,527

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салсгүй хэсэг болно.

**ШАРЫН ГОЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

	Тодруулга	2020	2019
Борлуулалтын орлого	23	63,915,550	61,966,116
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	24	(58,670,381)	(51,820,218)
Үнэ цэнийн бууралтын гарз	24	-	(623,530)
Нийт ашиг		5,425,169	9,522,368
Ерөнхий ба удирдлагын зардал	25	(2,373,629)	(3,392,572)
Борлуулалт ба маркетингийн зардал	26	(275,385)	(380,241)
Бусад орлого	27	2,215,437	1,125,438
Бусад зарлага	28	(2,628,356)	(1,719,678)
Үйл ажиллагааны ашиг		2,183,236	5,155,315
Санхүүгийн орлого	29	21,722	41,877
Санхүүгийн зардал	29	(4,293,059)	(6,536,939)
Түрээсийн хүүгийн зардал	11	-	(520,552)
Бусад олз ба (гарз)	30	71,616	(2,071,301)
Үйл ажиллагааны бус бусад орлого ба (зардал)	31	40,204	(2,076,561)
Татварын өмнөх алдагдал		(1,976,281)	(6,008,161)
Орлогын албан татварын зардал	32	(239,935)	(867,194)
Тайлант жилийн цэвэр алдагдал		(2,216,216)	(6,875,355)
Хувьцаа эзэмшигчдэд ногдох		(2,216,216)	6,875,355
Хяналтын бус багц эзэмшигчдэд ногдох		-	-
		(2,216,216)	(6,875,355)
Бусад дэлгэрэнгүй орлогын тайлан:			
Дахин үнэлгээний нэмэгдэл		-	7,705,766
Тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөөний дахин хэмжилт		-	77,660
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		(2,216,216)	908,071
Хувьцаа эзэмшигчид		(2,216,216)	908,071
Хяналтын бус хувьцаа эзэмшигчид		-	-
Нэгж хувьцаанд ногдох алдагдал (төгрөгөөр)	32	(217.91)	(676.03)

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ “ШАРЫН ГОЛ” ХК

ШАРЫН ГОЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

Тодруулга	Хувьцаат капитал	Нэмж тологдсон капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт	Хяналтын бус багц	Нийт
2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,017,024	23,145,158	9,632,468	(12,686,876)	21,107,774	-	21,107,774
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(6,875,355)	(6,875,355)	-	(6,875,355)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдалаар	22	-	7,705,766	77,660	7,783,426	-	7,783,426
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг(алдагдал)	-	-	7,705,766	(6,797,695)	908,071	-	908,071
Гаргасан хувьцаа	-	-	-	-	-	-	-
2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,017,024	23,145,158	17,338,234	(19,484,571)	22,015,845	-	22,015,845
Тайлант жилийн цэвэр алдагдал	-	-	-	(600,211)	(600,211)	-	(600,211)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах байдалаар	22	-	-	(1,616,047)	(1,616,047)	-	(1,616,047)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг(алдагдал)	-	-	-	(2,216,258)	(2,216,258)	-	(2,216,258)
Гаргасан хувьцаа	-	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжилт	-	-	(378,536)	378,536	-	-	-
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	1,017,024	23,145,158	16,959,698	(21,322,293)	19,799,587	-	19,799,587

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн сангуудын тайлангуудын санхүүг хэсэг болно.

ШАРЫН ГОЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)

	Толруулга	2020	2019
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Тайланг жилийн цэвэр ашиг(алдагдал)		(1,976,281)	(6,008,161)
<i>Тохиргооллол:</i>			
Орлогын албан татварын зардал		(107,194)	-
Үндсэн хөрөнгийн эзэгдлийн зардал	9	9,570,018	5,377,177
Биет бус хөрөнгийн хорогдуулга	10	36,183	36,157
Ашиглах эрхтэй хөрөнгийн хорогдуулга	11	7,027,451	1,065,763
Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгийн хорогдуулалт	14	879,454	29,284
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	30	(52,741)	-
Үндсэн хөрөнгө борлуулсаны олз	30	-	(24,097)
Охин компанийн хувьцаа борлуулсаны олз	30	-	-
Уурхайн хөрөнгийн хорогдуулга	12	8,787,154	589,459
Үндсэн хөрөнгийн үнэ цэнийн бууралт	9,30	103,764	1,641,754
Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн бууралтын гарз	30	-	453,644
Бараа материалын үнэ цэнийн бууралтын гарз	30	-	-
Уурхайн нөхөн сэргээлтийн сангийн нэмэгдэл	29,12	266,943	1,347,533
Ажилчдын тэтгэврийн сангийн зардал	19	(19,360)	(60,693)
Тэтгэврийн сангийн хүүгийн зардал	29,19	187,456	13,698
Найдваргүй авлагын зардал	24,6	227,938	635,387
Найдваргүй авлагын эргэн төлөлт	24,6	(70,343)	(11,857)
Хүүгийн зардал	29	901,177	4,263,578
Зээлийн, батлан даалт гаргасны алданги	16	-	2,063,393
Ажиллагсдын орон сууцны төлбөрийн өөрчлөлт	19	-	(8,719)
Түрээсийн хүүгийн зардал	10	820,742	520,552
Хүүгийн орлого	29	9,470	(26,384)
Гадаад валютын хэрэгжээгүй ханшийн зөрүүний гарз	29	378,208	726,281
Ажлын капиталын өөрчлөлтөөс өмнөх үйл ажиллагааны ашиг		26,970,040	12,623,769
<i>Ажлын капиталын өөрчлөлт:</i>			
Бараа материалын өсөлт		(1,606,711)	(272,327)
Дансны ба бусад авлагын өсөлт/(бууралт)		(1,410,289)	(2,693,802)
Урьдчилж төлсөн зардал, тооцооны өсөлт		1,230,465	(3,811,945)
Дансны болон бусад өглөгийн өсөлт		605,332	4,660,278
Гэрээний өр төлбөрийн өсөлт/(бууралт)		(254,945)	(2,040,078)
Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгөн урсгал		25,533,892	8,465,895
Төлсөн орлогын татвар	20	(172,624)	(218,053)
Тэтгэврийн сангийн төлөлт	19	(90,480)	(292,549)
Төлсөн хүү	16	-	(497,976)
Хүлээн авсан хүү	29	(766,096)	26,384
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		24,504,692	7,483,701
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Охин компанийн хувьцаа борлуулсан	13	-	-
Урт хугацаат эргэлтийн бус хөрөнгөнд урьдчилж төлсөн дүн	14	-	(264,277)
Дуусаагүй барилгын нэмэгдсэн өртөг	9	-	-
Үндсэн хөрөнгийн борлуулалт	9	-	55,000
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	9	(17,605,960)	(2,117,212)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	10	-	(660)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(17,605,960)	(2,327,149)

**ШАРЫН ГОЛ ХК БА ТҮҮНИЙ ОХИН КОМПАНИУД
АУДИТЛАГДСАН НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН
2020 ОНЫ 12 САРЫН 31-НЭЭР ТАСАЛБАР БОЛГОСОН
(МЯНГАН ТӨГРӨГӨӨР)**

Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Хүлээн авсан зээл	16	1,291,000	1,161,623
Эргэн төлсөн зээл	16	(662,372)	(3,890,945)
Түрээсийн буцаалт орж ирсэн мөнгө		-	-
Түрээсийн төлбөр	11	(4,429,655)	(5,270,797)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ		(3,801,027)	(8,000,119)
Мөнгө түүнтэй адилтгах хоронгийн цэвэр (бууралт)/осолт		3,097,705	(2,843,567)
Мөнгөний үлдэгдэл дэх ханшийн зөрүүгийн нөлөөлөл		332	(18,563)
Мөнгө ба түүнтэй адилтгах хоронгийн эхний үлдэгдэл	5	302,234	3,164,364
Мөнгө ба түүнтэй адилтгах хоронгийн эцсийн үлдэгдэл	5	3,400,271	302,234

Хавсаргасан тодруулгууд нь энэхүү нэгтгэсэн санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.

ГУРАВ: КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ, ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2020 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон бусад эрх зүйн актуудыг удирдлага болгон ажиллаж, компанийн ойрын болон хэтийн төлөвийг тодорхойлон шийдвэр гаргах, үйл ажиллагааг нь хянах зэргээр бүрэн эрхийнхээ хүрээнд тогтвортой, тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирлээ. Үүнд:

Нэг. Компанийн 2020 оны засаглалын төлөвлөлт

- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны хурлаар хэлэлцэх үндсэн асуудлын төлөвлөгөө
- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны мэдээлэл, үйл явдлын хуанли
- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод /аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо/-ын 2020 оны ажлын төлөвлөгөө
- ✓ Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахтай холбогдуулан хийх ажил цаг хугацааны график
- ✓ Компанийн 2020 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны төсөв зэрэг болно.

Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн засаглалын зарчмуудыг баримтлан жил бүр төлөвлөгөө хийж түүнийг мөрдлөг болгон ажилласаар ирлээ.

Хоёр. Мэдээ мэдээлэл

Мэдээ, мэдээлэл нь тухайн тайлант хугацааны бүхий л үйл ажиллагааг ил тод, нээлттэй байх үндсэн зарчмын илэрхийлэл юм. Тайлант хугацаанд ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлан:

- ✓ Компанийн хууль, дүрэм болон бусад засаглалтай холбогдсон үйл ажиллагааны журмууд.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын тов, хуралд хэлэлцэх асуудал, бүртгэлийн өдөр, хувьцаа эзэмшигчдийн санал авах хуудас, танилцах материалын жагсаалт зэргийг хууль дүрмийн дагуу өдөр тутмын сонин хэвлэлд 2 удаа, телевиз болон бусад мэдээлэх хэрэгслээр, хувьцаа эзэмшигчдийн хуралд хувьцаа эзэмшигчдийг өргөнөөр оролцуулахаар мэдээлж байлаа.
- ✓ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурлын бэлтгэл ажлын графикайн дагуу хийсэн ажлын гүйцэтгэлийг уг хуралд мэдээлсэн.
- ✓ Хувьцаа эзэмшигчдэд танилцуулах зорилгоор компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид, компанийн жилийн үйл ажиллагааны дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн аудитлагдсан тайлан, ТУЗ-ийн үйл ажиллагаа, засаглалын тайлан зэргийг танилцуулж байлаа.
- ✓ Компанийн 2020 оны 4-р сарын 24-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, шийдвэрийн талаарх мэдээллийг зохих журмаар мэдээлж байв.
- ✓ Мөн тайлант жилд ажилласан эрх бүхий албан тушаалтнуудын талаарх зураг бүхий мэдээлэл.
- ✓ Компанийн хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн төлөөлөл компанийн ТУЗ-д сонгогдон ажиллаж байгаатай холбогдуулан ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хурлаас гарах шийдвэрийн төслийг урьдчилан хүргүүлж тэдний санал зөвлөмжийг нь шийдвэрт тусган түүнийг хэрэгжүүлж байдаг юм.

Гурав. Хөрөнгийн зах зээл-компанийн хувьцаа

Компанийн хувьцааны 5 хувиас дээш багцыг эзэмшигчид:

Нийт хувьцаа 10,170,242

Д/д	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1.	SHG HOLDINGS 3	2,011,744	19.7
2.	SHG HOLDINGS 2	2,028,906	19.94
3.	NIHAN HOLDINGS	1,598,889	15.72
4.	ҮНДЭСНИЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БАНК	1,158,520	11.39
5.	SHG HOLDINGS 1	1,142,674	11.23
6.	MOGUL RESOURCES	1,000,000	9.83
ДҮН		8,942,333	87.8

Компанийн нийт хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдийг дээрх хүснэгтээр үзүүлэв.

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигч нэгдмэл
сонирхолтой компаниуд**

/2020 оны 12-р сарын 31-ний байдлаар/

Д/д	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Эзлэх хувь
1.	SHG HOLDINGS 3	2,011,744	19.7
2.	SHG HOLDINGS 2	2,028,906	19.8
3.	NIHAN HOLDINGS	1,598,889	15.6
4.	SHG HOLDINGS 1	1,142,674	11.1
Нийт		6,783,813	66.7

“Шарын гол” ХК нь 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 10,170,242 ширхэг энгийн хувьцаатай бөгөөд 1,016 хувьцаа эзэмшигчид уг хувьцааг эзэмшиж байна. Компанийн хувьцаа нь “Ард капитал групп ҮЦК” ХХК, “Би Ди Сек ҮЦК” ХК, “Нэйшнл сэкьюритис ҮЦК” ХХК зэрэг брокер диллерийн компаниудад төвлөрсөн байна.

**Дөрөв: Компанийн хувьцаа эзэмшигчдийн
Ээлжит хурал**

Тус компани нь компанийн эрх барих дээд байгууллага болох хувьцаа эзэмшигчдийн хурлыг КТХ-ийн дагуу жил бүрийн 4 дүгээр сард зарлан хуралдуулдаг. 2020 онд “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулах тухай” Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 3 дугаар сарын 15-ний өдрийн 06 дугаар тогтоол гарсан. Хурлыг 2020 оны 4 дүгээр сарын 24-ны өдөр 13 цагаас “Улаанбаатар” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсан.

Энэхүү хуралд:

- ✓ Компанийн 2019 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх батлах. Компанийн ТУЗ-ийн ажил, засаглалын талаарх мэдээлэл.
- ✓ Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны цалин урамшуулал, зардлын төсөв батлах.
- ✓ Компанийн ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэрийн талаарх мэдээлэл зэргийг хэлэлцэж шийдвэр гаргасан байна.

Энэхүү хурал 90.57 хувийн ирцтэй байв. Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалыг товхимол болгон хэвлэж хуулийн хугацаанд брокер, диллерийн компаниудаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргүүлсэн.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа, хурлын шийдвэрийн талаарх мэдээллийг компанийн болон МХБ-ийн цахим хуудаст байршуулж, уг хурлын материалыг хууль, журмын хугацаанд СЗХ, МХБ-д хүргүүллээ.

Тав. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хурал

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл, Компанийн тухай хууль, компанийн дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллах журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж ирлээ. Төлөөлөн удирдах зөвлөл нь тайлант хугацаанд ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүнтэйгээр ажилласан.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь 2020 онд төлөвлөсөн болон цаг хугацааны асуудлаар хэлэлцэх асуудлыг тухай бүрд нь хэлэлцэж зохих шийдвэрийг гаргаж байлаа. Хуралд гишүүдийг бүрэн оролцуулахын тулд, зарим гишүүдийн орон зайгаас шалтгаалан зарим хурлыг онлайн хэлбэрээр хуралдаж байв.

2020 онд ТУЗ-ийн хурлын 20 тогтоол гаргасан. Үүнд:

- Аудитын компани сонгон, гэрээ байгуулах
- Төлөөлөгчийн газрын удирдлага болон хаяг өөрчлөх тухай
- Зээлийн гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Ногдол ашиг хуваарилах эсэх тухай тухай
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит, ээлжит бус хурал хуралдуулах тухай
- Эд хөрөнгө акталж данснаас хасах болон өглөг, авлага данснаас хасах тухай
- Охин компани үүсгэн байгуулах тухай
- Компанийн 55 жилийн ойн арга хэмжээний тухай
- Барааны тэмдэг (лого)-ийн загвар батлах тухай

- Сумын эмнэлэгт хандив өгөх тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн зарим гишүүдийг түр томилох тухай
- Төлөөлөн удирдах зөвлөлийн нэр дэвшүүлэх хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай
- Компанийн гүйцэтгэх захирлыг чөлөөлөх болон томилох тухай
- Зөвшөөрөл болон эрх олгох тухай Зээл авахыг зөвшөөрөх тухай
- 2019 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт гаргах тухай
- Нүүрсний үнийн тухай зэрэг тогтоолуудыг тус тус гаргасан байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагаандаа компанийн засаглалын кодекс, зарчмыг мөрдлөг болгон компанийн засаглалын хөгжлийг манлайлагчдын эгнээнд багтаж ажиллахыг зорин ажиллаж байгаа билээ.

**2020 ОНД АЖИЛЛАСАН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН**



Г.Хулан
Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга



Б.Батбаатар
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



Т.Говьдэлгэр
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



Ө.Хишигсүх
ТУЗ-ийн гишүүн/ердийн/



Б.Тулга
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



Б.Итгэл
ТУЗ-ийн гишүүн /ердийн/



М.Батсүрэн
ТУЗ-ийн гишүүн /хараат бус/



О.Цэндсүрэн
ТУЗ-ийн гишүүн /хараат бус



Ж.Эрдэнэбат
ТУЗ-ийн гишүүн /ердийн/

**2020 ОНД АЖИЛЛАСАН КОМПАНИЙН
ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ**



Х.Уянга
Гүйцэтгэх захирал



С.Ганбат
Тэргүүн дэд захирал



Г.Мөнхбат
Үйлдвэрлэл эрхэлсэн дэд
захирал



Л.Эрдэнэжаргал
Санхүү, төлөвлөлтийн
хэлтсийн дарга

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮДЭД НЭР ДЭВШИГЧДИЙН
ТАНИЛЦУУЛГА**

Ердийн гишүүнд нэр дэвшигчид:



Бадангийн Батбаатар

- 1977 Варшав хотод төрсөн
- 2000 онд Жорж Мейсоны их сургууль төгссөн /бакалавр/
- 2004 онд Жорж Вашингтоны их сургууль төгссөн /магистр/
- Бизнесийн удирдлага, санхүүч мэргэжилтэй
- 2006-2007 онд Мянганы сорилын санд
- 2007-2009 онд “Си Си Пи” ХХК-д
- 2009 оноос одоог хүртэл “Си Би Эм” ХХК-д гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
- 2014 оны 06-р сараас 2020 оны 10-р сар хүртэл “Шарын гол” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан.



Хүрэлбаатарын Уянга

- 1986 онд Улаанбаатар хотод төрсөн
 - 2007 онд ШУТИС төгссөн
 - 2008 онд Отгонтэнгэр Их сургууль төгссөн
 - 2014 онд БНХАУ, Chongqing их сургууль төгссөн
 - Бизнесийн удирдлага, уул уурхайн эдийн засагч, кадастр-газар зохион байгуулалтын инженер мэргэжилтэй
 - 2007-2010 онд “Монголын Алт” ХХК-д ерөнхийлөгчийн туслах, цалингийн нярав, Зоос банканд зах зээлийн эдийн засагч, аудитор
 - 2012-2013 онд “Монголын Алт” ХХК-д зах зээл судлаач, оффис менежер
- 2014-2020 онд “Шарын гол” ХК-д хөрөнгө оруулалт, эдийн засгийн мэргэжилтэн, төслийн менежер
 - 2020 оны 10-р сараас “Шарын гол” ХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.



Наранбадрахын Батнайрамдал

- 1988 онд Өмнөговь аймагт төрсөн
- 2010 онд ИЗИС-ийн “Чингэс-Соосэ” олон улсын харилцааны сургууль
- 2020 онд МУИС-ийн хууль зүйн сургууль
- Олон улсын эрх зүйч, хуульч мэргэжилтэй, хууль зүйн ухааны магистрын зэрэгтэй
- 2010-2012 онд Үнэмлэхүй эрх хуулийн фирмд хуульч
- 2013-2016 онд “Хэрлэн онон туул” ББСБ-д хуулийн зөвлөх
- 2016-2019 онд “Говь Караван” ХХК-д хуулийн зөвлөх
- 2020 оноос Өмгөөллийн “Би И Би партнерс” хуулийн фирмийн Гүйцэтгэх захирал, партнер



Болдын Итгэл

- 1986 онд Улаанбаатар хотод төрсөн
 - 2005 онд АНУ-ын Иорктауны ахлах сургууль
 - 2008 онд АНУ-ын Жорж Мейсоны их сургууль тус тус төгссөн
 - Санхүүч мэргэжилтэй
 - 2009-2010 онд Хаан банканд теллер, зээлийн эдийн засагч, харилцааны менежер
 - 2010-2013 онд “Ньюком” ХХК-д шинжээч, хөрөнгө оруулалтын менежер
 - 2013 оноос одоо хүртэл “Нова Терра” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.
- 2018 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн.



Өрнөхийн Хишигсүх

- 1958 онд Улаанбаатар хотод төрсөн
 - 1979 онд ЦНДС төгссөн
 - 1984 онд ЦАТТ академи төгссөн
 - 1979-1981 онд Ардын армийн 133-р ангид авто техникийн албаны дарга
 - 1981-1984 онд МУИС-д багш
 - 1987-1989 онд Ардын армийн 133-р ангид штабын дарга
 - 1989-1990 онд СОТ-1 АТК-3-д дарга
 - 2000-2016 онд “Өргөө” ХХК-д захирал
 - 2016 оноос БХИС-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн
- 2018 оны 6-р сараас “Шарын гол” ХК-ийн Ерөнхий захирлаар ажиллаж байсан.



Жамаагийн Эрдэнэбат

- 1960 онд Улаанбаатар хотод төрсөн
- 1984 онд ОХУ-ын Кривой Рог-ын УУДСургууль
- 2008 онд ШУТИС-д магистрын зэрэг хамгаалсан
- Уул уурхайн инженер, маркшейдер мэргэжилтэй
- Монгол Улсын зөвлөх инженер
- Монгол Улсын гавьяат уурхайчин
- 1984-2020 онд Шарын гол ХК-д хэсгийн болон ерөнхий маркшейдер, ерөнхий инженер удирдлагын магистр



Тэрбишийн Говьдэлгэр

- 1984 онд Говь-Алтай аймагт төрсөн
- 2001 онд ГАА-н 10 жилийн сургууль
- 2001-2005 онд МУИС-ын геологийн бакалавр
- 2018-2020 онд МУИС-ын геологийн магистер
- 2005-2007 онд “Адамас майнинг” ХХК-д геологич
- 2007-2011 онд “Вюшер майпелосон” ХХК-д геологич
- 2011-2017 онд “Си би Эм” ХХК-д ахлах геологич
- 2017-2020 онд “Нагай” ХХК-д ерөнхий геологич
- 2020 оноос “Говькараван” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Хараат бүс гишүүнд нэр дэвшигчид:



Мажигсүрэнгийн Батсүрэн

- 1977 онд Улаанбаатар хотод төрсөн
- 2001 онд Улаанбаатар дээд сургууль төгссөн
- Хэрэглээний математикч мэргэжилтэй
- “Хай Би Ойл” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
- 2018 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн гишүүн



Охиндойн Цэндсүрэн

- 1965 онд төрсөн.
- 1983-1989 онд ОХУ, Уул уурхайн дээд сургууль-уул уурхайн инженер
- 1995-1997 онд Техникийн Их Сургууль- магистр
- 1996-1999 онд Улаанбаатар эрдэм дээд сургууль-хууль зүйн бакалавр
- 2002-2004 МУИС, Хууль зүйн сургууль-Хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан.
- 2003-2008 онд ОХУ, Екатеринбург хот Уул уурхайн академи- докторын сургалтанд хамрагдсан.
- 2007 онд ШУТИС, зөвлөх инженерийн сургалт тус тус төгссөн.
- Уул уурхайн инженер, Эрх зүйч мэргэжилтэй
- 1998-2000 онд ХХААҮЯам-ГУУСалбарын олборлолтын бодлого, хууль, эрх зүйн бодлого хариуцсан мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн.
- 2000-2002 онд Үйлдвэр худалдааны яам-ГУУСалбарын хамтарсан үйлдвэр, хууль, эрх зүйн бодлого хариуцсан ахлах мэргэжилтэн, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн гишүүн.
- 2002-2004 онд Үйлдвэр худалдааны яам-ГУУ-н бодлого зохицуулалтын газрын дэд дарга, эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дэд дарга.

- 2003 онд Үйлдвэр худалдааны яам-ГУУ-н бодлого зохицуулалтын даргын үүрэг гүйцэтгэгч, ГУУ-н салбарын мэргэжилтэнд мэргэшил, зөвлөх инженерийн зэрэг цол олгох комиссын дарга.
- 2004-2007 онд Үйлдвэр худалдааны яам-Геологи, уул уурхай, хүнд үйлдвэрийн газрын дэд дарга.
- 2008 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл-Геологи, уул уурхайн асуудал хариуцсан шинжээч.
- 2010-2015 онд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба-Эрдэс баялаг,эрчим хүчний асуудал хариуцсан ахлах референт
- 2015 онд Уул уурхайн яам-Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дарга



Гэрэлийн Хулан

- 1985 онд Токио хотод төрсөн
- 2000 онд Японы “Шото” дунд сургууль
- 2004 онд Японы “Кокусан” ахлах сургууль
- 2008 онд Японы Азийн их сургууль тус тус төгссөн
- Гадаад харилцааны мэргэжилтэй
- 2011-2013 онд “Солонго Эко Кампинг” ХХК-ийн ерөнхий захирал
- 2014-2018 онд “Интернационал Смарт Акуа Калча” /ИСАК/ ерөнхий менежер
- 2017-2018 онд “Данфийн ГХО” ХХК гүйцэтгэх захирлаар одоо хүртэл ажиллаж байна.
- 2018 оноос “Шарын гол” ХК-ийн ТУЗ-ийн дарга



Батбаярын Тулга

- 1986 онд Дархан-Уул аймагт төрсөн
- 2008 онд Санхүү Эдийн засгийн сургууль
- Бизнесийн эдийн засагч мэргэжилтэй
- 2008-2009 онд Зоос банканд зах зээлийн эдийн засагч, аудитор
- 2009-2011 онд Төрийн банканд хянан шалгагч, зах зээл үйл ажиллагааны эрсдэл
- 2011-2012 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд эрсдэлийн эдийн засагч
- 2012-2013 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд зээлийн эдийн засагч
- 2013-2016 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын санхүүжилтийн хэлтсийн дарга
- 2016-2017 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банканд байгууллагын банкны газрын дарга
- 2017-2020 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны гүйцэтгэх захирлаар ажилласан

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 03 сарын 17 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот

Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл
ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаарх ТУЗ-ийн дүгнэлтийн тухай

Компанийн тухай хуулийн 76.1.11, компанийн дүрмийн 8, 15, 11 дэх заалт, Төлөөлөн
удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг
ХАНГАЛТТАЙ гэж дүгнэсүгэй.
2. Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлт,
тайланг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд хэлэлцүүлэн батлуулахыг ТУЗ-ийн
дарга /Г.Хулан/-д даалгасугай.

ДАРГА Г.ХУЛАН



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 27

дугаар 01

Улаанбаатар

Компанийн жилийн үйл ажиллагааны болон
Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн
удирдах зөвлөлийн дүгнэлтийн тухай

“Шарын гол” хувьцаат компанийн 2020 оны жилийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлөөс оруулсан дүгнэлтийг хэлэлцээд;

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. “Шарын гол” хувьцаат компанийн 2020 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 сарын 27

дугаар 02

Улаанбаатар

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн
2021 оны цалин урамшуулал, зардлын төсөв
батлах тухай

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 62 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн хурлаас **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсвийг /хавсралтаар/ баталсугай.
2. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн зардлын төсвийн зарцуулалтанд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн цалин урамшууллын хороонд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

"Шарын гол" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
хурлын 2021 оны 4-р сарын 27-ны
өдрийн ____ дугаар тогтоолын хавсралт

"ШАРЫН ГОЛ" ХК-ИЙН ТУЗ-ИЙН 2021 ОНЫ ЗАРДЛЫН ТӨСӨВ

(мян.төг)

Д/д	Зардлын төрөл	НИЙТ ЗАРДАЛ м.төг
1	ТУЗ-ийн дарга, гишүүдийн цалин	171,000.0
2	НДШ	23,940.0
Дүн		194,940.0

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021.04.27

дугаар 03

Улаанбаатар хот

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн
ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай

Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 62.1.7 дахь заалт, “Компанийн дүрэм”-ийн 8.3 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнд

-

-

-

-

-

-

Хараат бус гишүүнд

-

-

-

нарыг

2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрөөс 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл 2 жилийн хугацаагаар сонгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ХУЛАН

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

“Шарын гол” ХК-ийн 2020 оны жилийн санхүүгийн тайлангаар татварын дараах үр дүн 155,698,026.86 төгрөгийн алдагдалтай гарч, компанийн санхүүгийн байдал зохих түвшинд хүрээгүйг тэмдэглээд, Компанийн тухай хуулийн 46.1, компанийн дүрмийн 12 дугаар бүлгийн заалтыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2020 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.
2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулан мэдээлэхийг Гүйцэтгэх захирал /Х.Уянга/-д даалгасугай.

ДАРГА Г.ХУЛАН



“Шарын гол” ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурлын хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчээс

САНАЛ АВАХ ХУУДАС

Хувьцаа эзэмшигчийн овог нэр

Регистрийн дугаар

ХЭ-ийн бүртгэлийн дугаар

Эзэмшиж буй хувьцааны төрөл

Тоо

Хурал 2021 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 13 цагаас “Улаанбаатар” зочид буудлын
хурлын танхимд болно.

Д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Таггалсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал
1	Компанийн 2020 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт. ТУЗ-ийн ажлын тайлан	Тогтоол ТУЗ-ийн дүгнэлтийг батлах				
2	Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2021 оны цалин урамшуулал, зардлын төсвийг батлах	Тогтоол Зардлын төсвийг батлах				
3	Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүдийг сонгох		Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/			
	1					
	2					
	3					
	4					
	5					
	6					
	Компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүдийг сонгох		Нэр дэвшигчдэд өгөх саналын тоо /кумулятив аргаар/			
	1					
	2					
3						
4						
4	Ногдол ашиг хуваарилаагүй тухай танилцуулга		Мэдээлэл тул санал хураахгүй			

Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр 4 дүгээр сарын 27 болно.

Санал өгсөн хувьцаа эзэмшигчийн гарын үсэг

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга

гишүүд:

.....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан

.....

.

.....

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Санал өгөх тэмдэглэл \checkmark тэмдэглэнэ.
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгоход санал хураах Кумулятив аргыг хэрэглэнэ. Кумулятив аргаар санал өгөх тоо _____
3. Тайлбар: саналын эрх бүхий энгийн хувьцааны тоог 9-өөр үржүүлж нийт саналын эрхийн тоог гаргана. Саналын эрхээ ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшиж буй нэг нэр дэвшигчид бүгдийг эсхүл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан өгөх эрхтэй.
Хувилбар А: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхээ бүгдийг ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон нэг нэр дэвшигчид өгч болно.
Хувилбар Б: Хувьцаа эзэмшигч А нийт 900 саналын эрхийн 600 эрхээ ТУЗ-ийн ердийн гишүүнээр сонгогдох 6 хүртэл нэр дэвшигчид, 300 эрхээ хараат бус гишүүнээр сонгогдох 3 хүртэл нэр дэвшигчид тус тус өгч болно. Хувьцаа эзэмшигч А саналын эрхээ ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшиж буй эсэхээс үл хамааран өөрийн сонгосон хэд хэдэн нэр дэвшигчид дурын харьцаагаар хуваарилан өгөх эрхтэй.
4. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс болон “Шарын гол” ХК-ийн УБ дахь Төлөөлөгчийн газар дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгч болно.
5. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 88026677, 99155399 утсаар лавлаж болно.